



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/508

Эрдэнэт

Тэмцээн зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.3 дугаар заалт, Монгол Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”-ын 2.1 дэх заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 4 дүгээр хуралдааны 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын нэрэмжит сум, аж ахуйн нэгж, байгууллагуудын Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, анхны тусламжийн нөхөрлөлүүдийн дунд “Аврагч-2017” тэмцээний 2017 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсугай.

2. Тэмцээний удирдамжийг нэгдүгээр, зохион байгуулах шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, үйл ажиллагааны зардлын төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнд шаардагдах 4300200 /Дөрвөн сая гурван зуун мянга хоёр зуун/ төгрөгийг Болзошгүй аваарийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

4. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус, төрийн өмчит, аж ахуйн нэгж байгууллагууд, анхны тусламжийн нөхөрлөлийн багийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж тэмцээнд оролцуулахыг байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтийг ханган биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар /н.Ганбаатар/, Улаан Загалмайн Хороо /н.Тунгалаг/, Хэв журам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн газар /н.Батбаяр/, холбогдох техник, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллахыг Зэвсэгт хүчний 186 дугаар анги /н.Жигжидсүрэн /, Биеийн тамир спортын газар /н.Зулбаатар/, Засаг даргын Тамгын газрын мэдээллийн төв /н.Оюун-Эрдэнэ/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Д.БАТЛУТ

**НӨХӨРЛӨЛ , ГИШҮҮДЭД БАЙХ ЭМ ХЭРЭГЛЭЛ, ОРООХ
БООХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

	Шаардлагатай зүйлсийн нэр	Тоо хэмжээ
А.Багаж хэрэгсэл		
1	Дамнуурга	Хэсэг /салаа/ бүрт 1 ширхэг
2	2.0x1.5хэмжээтэй дулаан хөнжил	Хэсэг /салаа/ бүрт 2 ширхэг
3	Дунд чөмөгний хугаралд тавих чиг	Хэсэг /салаа/бүрт 1 хос
4	Мөр, шуу, шилбэнд тавих чиг	Идэвхтэн тус бүрд 2 хос
5	Амаар аманд амьсгал өгөгч	Салаанд 1 ширхэг
6	Усны дашмаг	Идэвхтэн бүр 1 ширхэг
7	Гар чийдэн	Идэвхтэн бүр 1 ширхэг
8	Мохоо үзүүртэй хайч	Идэвхтэн бүр 1 ширхэг
9	Тэмдэглэлийн дэвтэр	Идэвхтэн бүр 1 ширхэг
10	Балын харандаа	Идэвхтэн бүр 1 ширхэг
11	Амны хаалт	Идэвхтэн бүр 1 ширхэг
12	Резинэн бээлий	Идэвхтэн бүр 1 хос
13	Нойтон салфетка	Идэвхтэн бүр 1 боодол
14	Гарын саван	Идэвхтэн бүр 1 ширхэг
15	Гарын жижиг алчуур	Идэвхтэн бүр 1 ширхэг
Б. Эм, ороох боох материал		
16	90 см х 90 см х100 см хэмжээний гурвалжин алчуур	Идэвхтэн бүр 1 ширхэг
17	Цуулбартай боолт	Идэвхтэн бүр 1 ширхэг
18	Гурвалжин алчуур	Идэвхтэн бүр 2 ширхэг
19	Ариун жийргэвч 10x10	Идэвхтэн бүр 5 ширхэг
20	10x7 хэмжээтэй бинт	Идэвхтэн бүр 1 ширхэг
21	5x10 хэмжээтэй бинт	Идэвхтэн бүр 1 ширхэг
22	Уян бинт 5x5	Идэвхтэн бүр 1 ширхэг
23	Уян бинт 10x5	Идэвхтэн бүр 1 ширхэг
24	Денаурат спирт 20.0	Идэвхтэн бүр 1 флакон
25	Иодын ханд 20.0	Идэвхтэн бүр 1 флакон
26	Хэвлий цээжний бүчтэй боолт	Идэвхтэн бүр 1 ширхэг
27	Сүлбээр зүү	Идэвхтэн бүр 5 ширхэг
28	Хөвөн 50 гр	Идэвхтэн бүр 1 боодол
29	Хоросол 100 гр	Идэвхтэн бүр 2 уут
30	Шархны лент	Идэвхтэн бүр 1 ширхэг
31	Хурууны боолт	Идэвхтэн бүр 2 уут
32	Цүнх	Идэвхтэн бүр 1 ширхэг

Аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 01 ны өдрийн 5.08 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



**“АВРАГЧ-2017” ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДЛАГАТАЙ ЗАРДАЛ**

д/д	Утга	Нэг бүрийн үнэ /төг/	Тоо ширхэг	Нийт үнэ /төг/	
<i>Нэг: Нийлбэр дүнгээр байр эзэлсэн анхны тусламжийн нөхөрлөлийг шагнах зардал</i>					
1	Мөнгөн шагнал	1-р байр	1	800,000	
2		2-р байр	1	600,000	
3		3-р байр	1	400,000	
4		4-р байр	1	200,000	
5		5-р байр	1	100,000	
6		Тусгай байр		2	100,000
7					
<i>Хоёр: Шагнал урамшууллын зардал</i>					
1	Медаль	6000	48	288,000	
2	Өргөмжлөл	15000	7	105,000	
3	Цом	100000	3	300,000	
<i>Гурав: Анхны тусламж үзүүлэх ажиллагааны талбайг хийхэд шаардагдах зардал</i>					
1	Утаат шашик /ДМ-11/	15545	22	342,000	
2	Анонс	9000	5 x 6	303,000	
<i>Дөрөв: Бусад зардал</i>					
1	ЭМАТАЦ-ын хүүхдэд оролцогчийн зардал	8000	40	320,000	
2	Зориудаар гал асаах шатахуун	АИ-80	84x1550=130,200	442,200	
		Дизель түлш	84x1750=147,000		
		АИ-92	100x1650=165000		
Нийт				4,300,200 төгрөг	